

~ Японы талаар илүү сайн мэдэж авцгаая ~

Гарчиг өөрчлөгдлөө! -“Ур чадварын дадлагажигчийн анд нөхөр”- өөс “とも(Томо)” болж өөрчлөгдлөө-

Япон хэлний “とも/томо” нь янз бүрийн утгатай. Гадаадын иргэд та бүхэнтэй “とも”-и/хамтдаа суралцах, “とも”-и/хамтран ажиллах, “とも”-и/хамтдаа хөгжилдөх, “とも”-и/зэрэгцэн амьдрах, мөн “ともだち”-и/анд найз болох гэсэн утгуудыг агуулсан. Цаашид ч Япон дахь ахуй амьдралд хэрэг болох мэдээлэл болон Япон хэлийг сурахад хэрэг болох санаа зэргийг Япон хэл, бусад 9 хэлээр түгээх болно. Зөвхөн Ур чадварын дадлагажигч, тусгай ур чадвартай гадаадын иргэд бус, төрөл бүрийн оршин суух статустайгаар Японд амьдарч байгаа хүмүүс уншиж, Японы талаар илүү сайн мэдэж аваасай гэж хүсч байна.

Сэдэв

2023 оны 7-р сар, зуны дугаар

Мангагаар дамжуулан мэдэж авцгаая. Японы дүрэм -Интернет гэмт хэргээс болгоомжилцгооё-

◇ Япон хэл сурах аппликейшны талаар мэдэх үү?

◇ Өндөр температуртай, чийгшил ихтэй Японы зун -Анхаарах зүйл болон зугаатай өнгөрөөх арга-
こくごのもり/kokugo no mori/Япон хэлний үгийн сан “上/ue/дээр” болон “下/shita/доор”

Манганаас мэдэж авцгаая. Японы соёл

— Интернет гэмт хэргээс болгоомжилцгооё —



Ур чадварын дадлагажигч Та бүхнийг ур чадварын дадлагаас өөр ажил болон цагийн ажил эрхлэх, дадлагажигчаар ажиллаж байгаа газраасаа гарч, өөр ажил эрхлэхийг хуулиар хориглосон байдаг. Мөн сүүлийн жилүүдэд гэмт хэргийн бүлэг нь интернетийн мэдээлэл, SNS-ийг ашиглан, Ур чадварын дадлагажигчдыг төрөл бүрийн гэмт хэрэгт турхирах жишээ олон гарч байна. Амар хялбараар өндөр хөлс авах боломжтой г.м нөхцөл сайтай цагийн ажил мэт харагдах боловч, энэ бол гэмт хэрэг юм. Энэ мэтийн гэмт хэрэгт оролцохгүй байхад анхаараарай.

Япон хэл сурах аппликейшны талаар мэдэх үү?

Япон хэл сайжраад ирэхээр, эргэн тойрныхоо хүмүүстэй илүү хөгжилтэй харилцах боломжтой болж магадгүй юм. Ажил хийнгээ суралцах нь амаргүй хэдий ч, богино цагаар ч хамаагүй, өөрийнхөө тааваар, хүндрэлгүйгээр Япон хэл суралцах боломжтой, үнэ төлбөргүй сургалтын аппликейшн байдаг. Та бүхэнд хэрэглэж үзэхийг санал болгож байна.

💡 Дата сүлжээний төлбөрийг хэрэглэгч нь төлнө. Хэрэглэхийнхээ өмнө дата сүлжээний орчноо магадлаарай.

● 「^{にほんごオンラインコース}いろいろ日本語オンラインコース」 JAPAN FOUNDATION

Япон дахь ахуй амьдрал болон ажилд шаардагдах харилцааны суурь чадварыг эзэмшихэд зориулсан бие даан суралцахад зориулсан сургалтын материал. “Суурь шат”, “Анхан шат 1”, “Анхан шат 2” гэсэн төрөлтэй ба 10 хэл дээр тайлбартай.

Аудио бичлэг сонсож, ярих дасгал болон дүрэм, ханз зэргийн дасгалыг гэйм тоглож байгаа мэтээр хийж, суралцах боломжтой.

Аппликейшныг татаж авбал, офлайн байсан ч хэрэглэх боломжтой.

<https://www.irodori-online.jp/go.jp/>



Эх сурвалж : JAPAN FOUNDATION

● 「げんばのにほんご」

Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллага (OTIT)

Машин тоног төхөөрөмж, металл, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, барилга, хөдөө аж ахуйн чиглэлийн ажлуудад тус тус хэрэглэгддэг хэлийг суралцах боломжтой сургалтын материал. 8 хэл дээр тайлбартай. “げんばのかいわ/ гэнба но кайва/ ажлын талбар дахь харилцан яриа”, “げんばのことは/ гэнба но котоба/ ажлын талбарт хэрэглэгдэх үг хэллэг”-ийг сонсон, ярих дасгал хийгээрэй. Үг хэллэгийн, ярианы тест ч байгаа.

アプリ/аппликейшныг App Store, эсвэл Google Play-ээс татаж авах боломжтой.

<https://www.otit.go.jp/kyozai/>



Эх сурвалж : OTIT

Дээрхээс гадна, Японы мэдээг хялбар Япон хэлээр дамжуулдаг сайтыг танилцуулъя.

● NEWS WEB EASY ^{にほんご}やさしい^か日本語^にで^{ゆー}書いた^すニュース

Аудио бичлэг сонсох, хэцүү үгийг толь бичгээс нь харах боломжтой тул, Япон хэл сурахад ашиглах боломжтой.

Чухал мэдээлэл байвал, эргэн тойрныхоо хүмүүс болон бусад ур чадварын дадлагажигч нартаа ч хэлж өгөөрэй.

<https://www3.nhk.or.jp/news/easy/>



Эх сурвалж : NHK WORLD JAPAN

Хэрэг болох аппликейшн, сайтыг ашиглан, зугаатайгаар суралцаарай.

JITCO-гоос төрөл бүрийн “Япон хэл сурахад зориулсан сургалтын материал”-ыг худалдаж байна. Ур чадварын дадлагын ажлын талбарт зонхилон тохиолдох харилцан яриаг түлхүү суралцах боломжтой текст ч байгаа. CD, DVD ч байгаа. “JITCO сургалтын материалын онлайн дэлгүүр”-ийн сайтаар орж үзээрэй.

<https://onlineshop.jitco.or.jp/>



Өндөр температуртай, чийгшил ихтэй Японы зун -Анхаарах зүйл болон зугаатай өнгөрөөх арга-



Борооны улирал дуусахаар халуун зун эхэлдэг. Японы зун бол чийгшил ихтэй, нойтон оргисон, халуун орны бүс нутгаас илүү биед мэдрэгдэх температур нь өндөр байдаг. Энэ халууны шалтгаан нь Японы зүүн өмнөд зүгээс ирдэг Огасавара өндөр даралт юм. Энэ өндөр даралт нь дулаан, чийглэг агаарыг зөөж, агаарын температур болон чийгшил ихээр нэмэгддэг. Сүүлийн үед хамгийн дээд температур нь 30°C-аас дээш “Зуны халуун өдөр”, 35°C-аас дээш “Хэт халуун өдөр” болон шөнөдөө ч агаарын температур 25°C-аас дээш байдаг “Халуун орны шөнө” ч олширч байна. Өндөр температуртай, чийгшил ихтэй орчинд удаан хугацаагаар байснаар, бага багаар биеийн доторх ус, давсны тэнцвэр

алдагдан, биеийн халуун зохицуулалт хэвийн явагдахгүй болж, биеийн дотор халуун хуримтлагдсан байдлыг “Дулааны цохилт” гэж хэлдэг. Зөвхөн гадаа биш, байшин барилга дотор байсан ч, мөн орой, шөнийн цагаар ч “Дулааны цохилт”-од өртөх тохиолдол байдаг. Хүндэрвэл, түргэн тусламжийн машинаар эмнэлэгт хүргэгдэж, зарим тохиолдолд нас барах тохиолдол ч байдаг. Сэнс, агааржуулагч ашиглан өрөөний температураа тохируулж, ам цангахыг мэдрэхээсээ урьтан шингэнээ нөхөх зэргээр арга хэмжээ аваарай.

Ур чадварын дадлагажигч Та бүхний дотор Японд ирээд анхны зунаа угтах хүн ч олон байгаа болов уу. Японы зуны зугаа гэвэл зуны фестивал, салют зэрэг юм. Японд зуны улиралд үндэсний хувцасны нэг төрөл болох юката өмсөх нь мөн нэг зугаа болдог. Сүүлийн үед юката түрээслүүлж, кицүкэ (гоё өмсгөх) хийж өгдөг газар ч олширсон бололтой тул, зуны фестивал, салюттай өдөр юката өмсөөд гадагшаа гарахыг санал болгож байна. Ид халуун зуны шөнийн тэнгэрт томоор цэцэглэх гэрэлт, дуут салют нь маш үзэсгэлэнтэй ба “Японы зун”-ыг биеэр мэдрэх болно.

Халуун өдрүүд удаан үргэлжилдэг Японы зунд, зуны шөнийн арга хэмжээ зэргийг сонирхож зугаацангаа, агааржуулагчаар биеэ хэт хөргөлгүй, шим тэжээлээ сайн авч, “Зуны ядаргаа” тусалгүйгээр эрүүл цоглог өнгөрөөхийг хичээгээрэй.

Кокуго-но-мори

Энэ нь Япон хэлний үг хэллэг, ханз болон эдгээрийн хэрэглэх аргын талаар суралцахад зориулсан сурах бичиг болно. Зугаатайгаар хариуг нь бодож олцгооё. (Хариу нь дараагийн хуудсанд байгаа.)

Ур чадварын дадлагажигч, Энэ сарын зураг



Акита мужийн Юзава хотод 3 жилийн дараа зохион байгуулагдсан “Танабата Эдоороо Фестивал”-д Вьетнамаас ирсэн ур чадварын дадлагажигч нар оролцсон нь. Орон нутгийн фестивалын уур амьсгал, уламжлалт арга хэмжээнд анх удаа биечлэн оролцож, өдрөө үр өгөөжтэй өнгөрөөжээ.

※2022 оны 9-р сард нийтлэгдсэн
(すばる事業協同組合)

Ур чадварын дадлагажигчийн хүлээн авагч байгууллагуудаас JITCO-гийн цахим хуудсанд ирүүлсэн “Ур чадварын дадлагын Days”-ээс нэг зургийг сонгон нийтэлж байна. “Ур чадварын дадлагын Days” хуудас болон зураг ирүүлэх удирдамжийг эндээс харна уу.

(<https://www.jitco.or.jp/ja/days/>)



Зөвлөгөө өгөх цонхны танилцуулга

Асуудал тулгарсан үед ...? (<https://www.otit.go.jp/notebook/>)

ОТИТ (Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллага)-ын “Асуудал тулгарсан үед ур чадварын дадлагажигчдын эх хэл дээр нь зөвлөгөө өгөх цонх” болон бүс нутгийн зөвлөгөө өгөх цонх, гамшгаас сэргийлэх мэдээлэл, хэрэг болох аппликейшн “げんばの にほんご /Гэнба но нихонго/Ажлын байранд хэрэглэх Япон хэл”, “Ур чадварын дадлагажигчдад зориулсан гарын авлага” зэргийг ашиглах боломжтой.



「上」「下」は位置や程度を表しますが、送りがなをつけた動詞になると、実に幅広い意味をもつ言葉になります。「下さい」は「くれ」のていねいな言い方です。問題には取り上げませんでしたが、「(召し)あがる」は「食べる」/taberu/идэх-ийн, 「(そちらに)上がる/sochira ni agaru/ (таны байгаа газар) бараалхах” нь “行く/iku/явах, たずねる/tazuneru/очих”-ын хүндэтгэсэн хэллэг юм.

“上/ue/дээр”, “下/shita/доор” нь байрлал болон түвшнийг илэрхийлэх ба “送りがな/okurigana/ханзны дагавар” залгасан үйл үг болохоор, маш өргөн хүрээний утга агуулсан үг болдог. “下さい/kudasai/өгнө үү” нь “くれ/kure/өг”-ийн эелдэг хэллэг юм. Даалгаварт оруулаагүй жишээ дурьдвал, “(召し)あがる/meshi-agaru/зооглох” нь “食べる/taberu/идэх”-ийн, “(そちらに)上がる/sochira ni agaru/ (таны байгаа газар) бараалхах” нь “行く/iku/явах, たずねる/tazuneru/очих”-ын хүндэтгэсэн хэллэг юм.

とも

2023年7月 夏季号

2023年7月1日発行

発行

公益財団法人 国際人材協力機構 (JITCO)

総務部広報室

〒108-0023

東京都港区芝浦2-11-5

五十嵐ビルディング

03-4306-1166 (ダイヤルイン)

<https://www.jitco.or.jp/>

電話

JITCO ホームページ